

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2024 оны ...дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар....

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Журам шинэчлэн баталж, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 402 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах зөвлөлийн ажиллах журам”-д доор дурдсан агуулга бүхий дараах зүйл нэмсүгэй.

1/ Ес. Зөвлөлийн гишүүнээр төрийн бус байгууллагын төлөөллийг сонгох

9.1. Зөвлөлийн гишүүнээр нэр дэвших хүсэлт гаргасан төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг өмнөх зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэгээс доошгүй сарын өмнө сонгон шалгаруулалтын баг сонгон шалгаруулна.

9.2. Сонгон шалгаруулах багийг тухайн зөвлөл, дэд зөвлөл, салбар зөвлөлийн даргын тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

9.2.1. төрийн байгууллагын төлөөлөл 2 хүн;

9.2.2. төрийн бус байгууллагын төлөөлөл 2 хүн;

9.2.3. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаар ойлголттой, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагатай хамааралгүй судлаач 1 хүн.

9.3. Баг үзүүлэлт бүрийг 0-5 оноогоор үнэлж, хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг гишүүнээр сонгогдсонд тооцон нийтэд зарлана.

9.4. Үндэсний зөвлөлд 15 хүртэлх, дэд болон салбар зөвлөлд 5 хүртэлх төрийн бус байгууллагын төлөөллийг 4 жилийн хугацаагаар сонгон шалгаруулна.

9.5. Дараах шалгуурыг хангасан төрийн бус байгууллага төлөөллөө Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж болно:

9.5.1. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр таваас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа;

9.5.2. үйл ажиллагаа явуулах ажлын байр, хүний нөөцтэй байх;

9.5.3. төрийн болон олон улсын байгууллагын захиалгаар гурваас доошгүй ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн байх;

9.5.4. хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын нэгдсэн холбооны тухайд энэ журмын 9.2.1-т заасан хугацаа хамаарахгүй байж болно.

9.6.Доорх шалгуурыг хангасан Төрийн бус байгууллага нь төлөөллөө дэд болон салбар зөвлөлийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлж болно:

9.6.1.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх ашгийг хамгаалах чиглэлээр гурваас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулж байгаа;

9.6.2.төрийн бус байгууллага нь үйл ажиллагаа явуулах ажлын байр, хүний нөөцтэй байх;

9.6.3.тухайн салбарын бодлого, шийдвэр, үйл ажиллагаанд санал өгч хамтран ажиллаж ирсэн туршлагатай.

9.7.Үндэсний, дэд, салбар зөвлөлийн гишүүнээр нэр дэвшигч нь дараах агуулга бүхий танилцуулгыг бэлтгэж, шалгаруулах багт танилцуулна:

9.7.1.хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр санаачилсан ажил, үр дүн;

9.7.2.хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үндэсний зөвлөлийн үйл ажиллагаанд оруулах хувь нэмэр;

9.7.3.санаачилж зохион байгуулах арга хэмжээ;

9.7.4.санаачилгын хүрээнд гарах үр дүн, үр нөлөө.

9.8. Энэ журмын 9.1-д заасан зөвлөлийн гишүүн нь төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх дэд зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн салбар зөвлөлд давхар ажиллахыг хориглоно.

9.9.Зөвлөлийн гишүүн тайлангаа жил бүр иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагуудад танилцуулах бөгөөд ажлын үр дүн, хурлын ирцийг үндэслэн 30 хүртэлх хувийг нэг удаа улируулан томилж болно.

2. Мөн журмын 3.3 дахь хэсгийн “төрийн бус” гэсний дараа “байгууллага болон хувийн хэвшлийн” гэж нэмсүгэй.

3. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.2, 3.6 дахь хэсэг, 7.2.1 дэх заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ “3.2. Дарга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, дэд дарга нь хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл байна.

2/ 3.6.Зөвлөлийн дэргэд холбогдох асуудлаар бодлогын зөвлөл ажиллах бөгөөд бодлогын зөвлөл нь яамд, төрийн байгууллагуудад өгөх бодлогын зөвлөмж, хууль тогтоомжид тусгах санал боловсруулж Үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлнэ. Шаардлагатай бол Үндэсний зөвлөлийн даалгаснаар хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, санал зөвлөмжөө үндэсний зөвлөлд танилцуулна.”

3/ 7.2.1.зөвлөлийн дараа жилийн ажлын төлөвлөгөө, шаардагдах төсвийг боловсруулан жил бүрийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор батлуулах, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах;”.

4. Тус журмын 7.1 дэх хэсгийн “төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “төрийн захиргааны байгуулга” гэж, 9 дэх зүйлийг 10 дахь зүйл болгон тус тус өөрчилсүгэй.